

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02-р сарын 17-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

### *Ногдол ашиг хуваарилах тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвекор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.18 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.16 дахь заалт, болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 2,878,282,678 (хоёр тэрбум найман зуун далан найман сая хоёр зуун наян хоёр мянга зургаан зуун далан найман) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 38 (гучин найман) төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

